

Эх орончдын нэгдсэн намын Бага хурлын
2020 оны 3-р сарын 22-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталж,
намын Удирдах зөвлөлийн 2020 оны 4-р сарын 8-ны өдрийн хурлаар
нэмэлт өөрчлөлтийг батлав.

Эх орончдын нэгдсэн нам (ЭОНН)-ын 2020 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр

Эх орончдын нэгдсэн намын 2020 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр бол монголчуудын сүүлийн 30 жил туулсан зам, мэдлэг туршлага, алдаа оноо, тулгамдсан асуудлуудаас сургамж авч Монгол Улс, Монголын төр, Монголын ард түмний язгуур эрх ашигт зохируулан боловсруулсан үндэсний үзэл санаа бүхий эх оронч бодлого, ухаарал мөн.

Өнөөгийн улс төр, нийгэм, эдийн засгийн хямрал, оюун санааны задрал, ёс суртахууны ялзрал, байгаль орчны доройтол, шударга ёсны гажуудал, ардчиллын мухардал, сэтгэлгээний ядуурал нь шилжилтийн үед сонгосон улс төр, нийгэм-эдийн засгийн загварын алдаа бөгөөд улс, үндэстнээ энэ гамшиг сүйрлээс аврахад улс төр, эдийн засаг, нийгмийн цоо шинэ бодлого зорилт шаардлагатай юм.

Иймд **“ИХ ЭРГЭЛТИЙН БОДЛОГО”** хөгжлийн хөтөлбөрөө сонгогчдодоо өргөн дэвшүүлж байна.

1. Их эргэлтийн бодлого:САЙН ТӨР, ЗАСАГ

Үндэсний эрх ашгаа дээдлэн улс орныхоо хөгжил дэвшлийг манлайлдаг-нэр хүндтэй, ард түмний ашиг сонирхлыг хүндэтгэн бодлого,зорилтоо хэрэгжүүлдэг-хариуцлагатай, эх орон, ард түмэн, монгол хүний төлөө-хүмүүнлэг,энэрэнгүй,ардчилсан сайн төр,засаг төлөвшүүлнэ.

Сайн төр, засаг

1.1 Төр, засгийн үйлчилгээг цахимжуулж, хиймэл оюун ухаан, шинэ технологи нэвтрүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.

1.2 Төрийн захиргааны, тусгай, үйлчилгээний албан хаагчдын намын гишүүнчлэл, дэмжигч статусыг хориглож, төрийн албыг улс төрийн хараат байдлаас чөлөөлнө.

1.3 Хатуу гишүүнчлэлээр барьцаалах, сум, орон нутагт салбартай байх, хандив, тусламж авах, үл хөдлөх хөрөнгө эзэмших, төрийн албаны үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр хутгалдахыг намуудад хатуу хориглож, мэргэшсэн улстөрчдийн хязгаарлагдмал гишүүнчлэлтэй, дэмжигчдийн статустай, сонгуульд авсан суудлын тоогоор төсвөөс санхүүждэг, байрны хангамж эдэлдэг, улс орны хөгжлийн бодлого

боловсруулж улс төрийн сангаас санхүүжүүлдэг институц байхаар хуульчилж, намуудыг татан буулгаж, дахин бүртгэл явуулна.

1.4 Төрийн жинхэнэ албыг улстөржүүлж, нөлөөллөө аливаа хэлбэрээр тогтоосон намыг татан буулгана.

1.5 Нутгийн өөрөө удирдах ёсыг иргэдийн мэдэлд бүрэн шилжүүлж, бүх шатны Иргэдийн хурлын сонгуулийг намаас ангид явуулах эрх зүйн орчныг үе шаттайгаар бүрдүүлнэ.

1.6 УИХ-д суудалтай эрх баригч намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн биелэлтэд ээлжит сонгууль зарлахаас 6 сарын өмнө Үндэсний аудитын газраар аудит хийлгэж, сонгогчдод мэдээлнэ.

1.7 Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндсэн хуулийн цэц, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний аудитын газар, Үндэсний бүртгэл, статистикийн газар, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Үндэсний олон нийтийн радио, телевизийн дарга нар, Монголбанкны Ерөнхийлөгч, Улсын Ерөнхий прокурорыг улс төрийн намын гишүүн, улстөрч томилохыг хориглож, мэргэжлийн холбоо, олон нийтийн байгууллагаас нэр дэвшүүлж, парламент батламжлахаар хуульчилна.

1.8 Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", "Алсын хараа -2050" бодлогын баримт бичигт тусгасан хөгжлийн зорилтуудыг харгалзан Засгийн газрын бүтцийг тогтооно.

1.9 Засгийн газрын тохируулагч агентлаг Үнэ, стандартын хороог байгуулж, хэрэглээний үнийн зах зээлийн судалгаа, жишиг үнийг нэгдмэл байдлаар гаргаснаар үнийн монопол, тендер, худалдан авалтын луйврыг арилгаж, гааль, татварын ажлыг хөнгөвчилнө.

1.10 Төрийн улс төрийн албан хаагч, төрийн захиргааны албан хаагч, төрийн тусгай албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчийн эрх зүйн байдлын тухай багц хуулийг батлан гаргаж, тухайн төрийн алба бүрийн шалгуур үзүүлэлт, стандарт, эдлэх эрх, үүрэг, хариуцлага, хангамж, карьерийн зарчмыг тодорхой тусган хэрэгжүүлэх бөгөөд хуулийн дагуу дахин аттестатчилал явуулна.

1.11 Төрийн албаны зөвлөлийн статусыг хараат бус, олон нийтийн байхаар өөрчилж, зөвлөлийн бүрэлдэхүүнд төрд татвар төлдөг, төрөөр үйлчлүүлдэг байгууллага, иргэний нийгэм, иргэдийн төлөөллийг тэнцвэртэй, өргөн хүрээтэй оролцуулж, нийгэм, олон нийтийн хяналтын механизмыг төлөвшүүлнэ.

1.12 Засгийн газрын дэргэд Хүний нөөцийн тусгай хороог байгуулж, шилдэг мэргэшсэн хүнийг төрд ажиллуулах, чадамж, бүтээлд суурилсан хүний нөөцийн сан бий болгоно.

1.13 Үндэсний аюулгүй байдал, хууль, хяналт, батлан хамгаалах салбар болон гадаад бодлого, стратегийн ач холбогдолтой ашигт малтмал, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх байгууллагуудын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг томилохдоо хүний нөөцийн санд бүртгэлтэй, мэргэшсэн хүнийг зөвхөн сонгоно.



1.14 Төрийн албаны шалгалтыг боловсронгуй болгож, олон улсын жишгийн дагуу нийтлэг ерөнхий шалгалтаас гадна тухайн салбарын онцлогтой мэргэжлийн шалгалт авдаг болгоно.

1.15 Төрийн албанд гаднаас ажил үүрэг гэрээгээр гүйцэтгэх боломжийг нээж, үргүй зардал, орон тоог хэмнэх, төрийн албаны зарим салбарт ажлын цагийн уян хатан систем (Flexitime system) нэвтрүүлнэ.

1.16 Төрийн албанд ажиллагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Төрийн албан хаагчдын холбоог шинээр байгуулна.

1.17 Сонгуулийн хуульд төр ба ард түмний хооронд гэрээ байгуулах заалтыг нэмж оруулах замаар ард түмний хяналтыг тогтоож, хариуцлагатай улс төрийг бий болгоно.

1.18 Парламент бүрэн эрхийн хугацааны эхний хагаст Сонгуулийн хуулийг өөрчилж болох бөгөөд үүнийг үндэсний зөвшилцөлгүйгээр хийхийг хориглоно.

1.19 Оффшор банканд данс, хадгаламжтай этгээдийг бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх, төрийн албанд томилон ажиллуулахаас татгалзана.

1.20 Парламентад суудалтай болон суудалгүй намуудын Улстөрийн байнгын зөвлөлийг парламентийн дэргэд байгуулна.

1.21 Төрөөс улс төр-бизнесийн олигархи бүлэглэлийг зайлуулж, өөрсдөөр нь хүлээн зөвшөөрүүлж, ард түмнээс завшсан хөрөнгөө ядуурлыг бууруулах үйлсэд зориулахыг шаардана.

1.22 Цэрэг, цагдаа, тагнуулыг улс төрөөс хараат бус байлгаж, ард түмний эсрэг ашиглахыг хориглоно.

1.23 Гадны шашны гаж нөлөө, соёлын түрэмгийллээс үндэсний оюун санаа, үнэт зүйлс, соёлыг хамгаалах бодлого явуулна.

1.24 Үндэсний соёл, урлагаар дамжуулан үндэсний бахархлыг төлөвшүүлнэ.

1.25 Хэвлэл, мэдээллийн хэрэгслийг улс төр, эдийн засгийн бүлэглэлийн нөлөөнөөс ангигруулж, олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлнэ.

1.26 Шинжлэх ухааны салбарыг суурь судалгаа, инновацийн нээлтэд чиглүүлж, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтыг зах зээлийн зарчимд нийцүүлнэ.

1.27 Үзэл бодлоор ялгаварлах, хавчин гадуурхах, мөрдөн мөшгөх аливаа илрэлтэй хатуу тэмцэнэ.


1.28 Прокурорын байгууллагын мөрдөн шалгах эрх хэмжээг өргөжүүлж, төрийн тусгай албан хаагчдын хэрэг, зөрчлийг Мөрдөн шалгах албыг сэргээн ажиллуулна.

1.29 Үндэсний аудитын газрын хараат бус байдлыг бэхжүүлж, хэрэг, зөрчил бүртгэх эрх хэмжээг нэмэгдүүлнэ.

1.30 Үндэсний олон нийтийн радио, телевизийн чөлөөт, хараат бус, бие даасан байдал, менежментийг бэхжүүлж, нийгмийн хариуцлага, хяналтыг сайжруулна.

1.31 Төрийн санхүүжилтийн үйлчилгээнд ваучерийн аргыг түлхүү хэрэглэнэ.

1.32 Төрийн албаны шинэчлэлийг гүнзгийрүүлж, мууг халж, сайныг тогтоох зарчим хэрэгжүүлнэ.



Уул уурхай

1.33 Ашигт малтмалын төрөл, ордын нөөцийг харгалзахгүйгээр байгалийн баялаг улсын өмч гэж үзэж, ард түмэн бүрэн хянах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.34 Монголын уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэлгээг сайжруулахад онцгой анхаарч, үнийн нэгдсэн бодлого зохицуулалт хийнэ.

1.35 Монгол Улсын Засгийн газарт мэдэгдэлгүйгээр олон улсын зах зээлд монголын баялгийг барьцаалан хөрөнгө босгох, зөвшөөрөлгүйгээр эрх шилжүүлэх, худалдахыг хориглоно.

1.36 Үндэсний эрх ашигт харшилсан олон улсын гэрээ, хэлцлүүдийг дахин хянаж, хамтрагч этгээдтэй хэлэлцэн, засч залруулах, сайжруулах арга хэмжээ авна.

1.37 Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг шинэчлэн сайжруулах гарцыг олж, үндэсний эрх ашгийг хохироохгүйгээр шийдвэрлэнэ.

1.38 Оюутолгой болон гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүдийн экспортын орлогыг Монголын банкаар заавал дамжуулах үүргийг хуульчилна.

1.39 Таван толгойн ордыг ард түмний мэдэлд 100 хувь үлдээж, төслийг хэрэгжүүлэх эрхийг үндэсний хөрөнгө оруулагчдад давуу эрхээр олгоно.

1.40 Улсын төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийсэн болон стратегийн орд газруудын хууль бусаар олгогдсон лицензийг цуцалж, буруутай этгээдүүдэд хариуцлага тооцуулна.

1.41 Нөөц нь тогтоогдсон ордуудыг дахин нягталж, стратегийн ордод хамруулах эсэхийг шийдвэрлэнэ.

1.42 Дархан цаазат газар, төрийн тусгай хамгаалалттай газар, хилийн бүс, төв суурин газар хамруулан олгосон лицензийг цуцалж, малчдын хаваржаа, өвөлжөө, булаг шандын эх, оршуулгын газрыг тусгай зөвшөөрлөөс хэсэгчлэн чөлөөлүүлнэ.

1.43 Байгалийн баялгийг өвөг дээдсийн буян, өнөө бидний хишиг, үр хойчийн өмч хэмээн үзэж, улсын төсвөөс ангид, хараат бус Үндэсний баялгийн сан байгуулж, ашигт малтмалын нөөц ашигласны татвар, хураамжийн орлогын 50 хувиас доошгүйг тогтмол төвлөрүүлэн ирээдүйд хадгална.

1.44 Ашигт малтмал олборлогч бүх аж ахуйн нэгж өмчийн хэлбэр харгалзахгүйгээр жил бүр Үндэсний нөөцийн санд уул уурхайн бүтээгдэхүүн борлуулсан ашгийн 10 хувийг төвлөрүүлэхээр хуульчилна.

Үйлдвэржүүлэлт

1.45 Хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх бодлогын хэмжээнд тавьж, өндөр технологи нэвтрүүлсэн боловсруулах үйлдвэр, экспортод чиглэсэн экологийн цэвэр органик хүнсний үйлдвэрлэлийг тууштай дэмжинэ.

1.46 Экспортын чиг баримжаатай эрчим хүч, дулаан, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрийг хувийн болон гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулахыг дэмжинэ.

1.47 Аж үйлдвэрийн гуравдугаар хувьсгалыг өрнүүлж, уул уурхайн түүхий эд боловсруулах хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого дэвшүүлнэ.

1.48 Жижиг, дунд үйлдвэрийн бүртгэл, тусгай зөвшөөрлийг хялбарчилж, бизнесийн таатай орчин бүрдүүлнэ.

Хотжилт

1.49 Нийслэл Улаанбаатар хотын төлөвлөлтийг шинэчилж, эрх зүйн таатай нөхцөлтэй дагуул хотуудаар тэлэх бодлого баримтлана.

1.50 Улаанбаатар, Дархан, Эрдэнэтээс гадна баруун бүсэд Хархорин, Ховд, зүүн бүсэд Өндөрхаан, говийн бүсэд Даланзадгад гэсэн бүсийн статустай хотуудыг хөнгөн, хүнд үйлдвэр, шинжлэх ухаан-үйлдвэр-технологийн парк, их, дээд сургууль, мэргэжлийн сургууль, аялал жуулчлалыг онцлогтой хөгжүүлнэ.

1.51 Хүн амын тоо, эдийн засгийн чадавх, дэд бүтцийн хөгжил, газар зүйн байршил, үндэсний аюулгүй байдалд үзүүлэх нөлөө зэрэг хүчин зүйлийг харгалзан засаг захиргааны нэгжийн өөрчлөлт шинэчлэлийг эхлүүлж, аймгийн төвүүдийг орон нутгийн статустай хотын бодлогоор хөгжүүлнэ.

1.52 Аялал жуулчлалын үндэсний хөгжлийн хөтөлбөр, үндэсний сүлжээ байгуулж, аялал жуулчлалын тусгай бүс, цогцолбор газруудыг хөгжүүлнэ.

Дэд бүтэц

1.53 Хэвтээ тэнхлэгийн төмөр замыг барих судалгаа,техник, эдийн засгийн үнэлгээг хийж эхлүүлнэ.

1.54 Улаанбаатар хотыг тойруулан 2 урсгалтай төмөр зам барих төслийн ажлыг концессын гэрээгээр хэрэгжүүлэх санаачилга гаргана.

1.55 Улаанбаатар хотын авто замын ачааллыг бууруулахад чиглэсэн давхар зам, гүүр, гүүрэн гарц барих төслүүдийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, концессоор шийдвэрлэхийг дэмжинэ.

1.56 Нийслэл, аймаг, сум, суурин газрын гэр хорооллын бие даасан,эко дэд бүтцийн хөгжлийг дэмжиж, санхүүгийн урамшуулал үзүүлнэ .

1.57 Хот, суурин газрын нийтийн тээврийн асуудлыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бүрэн шийдвэрлэнэ.

2. Их эргэлтийн бодлого: ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГААР ТОГТНОЛ

Төсвийн алдагдал,хяналт, тооцоогүй гадаад, дотоод өр, өрийн сүлжээ, инфляцийн дарамт, дефляцийн аюул,төгрөгийн ханшны уналт, гадаад валютын ноёрхол, банкны зээлийн хүүгийн өсөлт, далд авлигыг таслан зогсоож, үндэсний эдийн засгаа сэргээн бэхжүүлнэ.

Эдийн засгийн бодлого

2.1 “Эдийн засаг, стратегийн ач холбогдолтой салбаруудад төрийн хяналт тогтоох тухай хууль” санаачлан батлуулж, өмнө хувьчлагдсан стратегийн ач холбогдолтой объектуудад төрийн хяналтыг тогтоож, үр ашгийг дээшлүүлнэ.

2.2 Архи, согтууруулах ундааны үйлдвэрлэлд төрийн монопол тогтооно.

2.3 Монгол Улсын үндэсний нийт баялгийг үнэлж, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцлийг бүрдүүлнэ.

2.4 Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчилж, хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэр, онцлог, хэмжээ, эдийн засгийн үр өгөөж, технологи дамжуулалт, ашгийн урсгал, байршил, дахин хөрөнгө оруулалт, түүний өсөлт зэргийг харгалзан аливаа хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулдаг болгоно.

2.5 Гадаадын хөрөнгө оруулалтыг дэд бүтэц, хот байгуулалт, гэр хорооллын хөгжил, боловсрол, шинжлэх ухаан, технологийн салбарт оруулахыг хөхиүлэн дэмжинэ.

2.6 Үндэсний хөрөнгө оруулагчид ижил таатай нөхцөл олгож, тэднийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

2.7 Үнэт цаасны зах зээлийн хөгжлийг гүнзгийрүүлж, Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг дэлхийн жишигт хүргэж, иргэд сонирхсон хувьцаагаа чөлөөтэй арилжих, эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

2.8 Ипотекийн зээлийн боломжийг өргөжүүлж, хүүг бууруулж, бага орлоготой иргэд, малчид, гадаадад ажилладаг иргэд, залуу гэр бүл хамрагдах нөхцлийг бүрдүүлнэ.

2.9 Экспорт, импортын нэг цонхны бодлого хэрэгжүүлж, үндэсний үйлдвэрлэлээ дэмжинэ.

2.10 Экспортыг дэмжиж, монгол бүтээгдэхүүн гадаадын зах зээлд нэвтрэх таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн гадаад харилцааг идэвхжүүлнэ.

2.11 Хоёр хөрштэй эдийн засгийн коридор байгуулах, гуравдагч орнуудын зах зээлд харилцан татваргүй бараа нийлүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

2.12 Монгол Улсын стратегийн бараа бүтээгдэхүүний импортын үндсэн чиглэлийг шинэчилж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний татварыг ялгавартай тогтоож, “Өдөр тутмын худалдан авалтын тухай хууль” санаачлан хэрэгжүүлнэ.

2.13 Иргэдийн ахуй амьдралд зохицсон уян хатан санхүүгийн бичил үйлчилгээг нэвтрүүлж, ажилтай, орлоготой иргэдээ бодлогоор дэмжиж, хүчирхэг дундаж давхаргыг бий болгохыг зорино.

2.14 “Монгол иргэдийн амьжиргааны орчин нөхцөлийг хамгаалах тухай хууль” санаачилна.

2.15 Стратегийн ач холбогдолгүй төрийн өмчийг хувьчилна.

2.16 Үндэсний хөрөнгө оруулалтыг хөгжүүлэх бодлогоор “Ард түмний IPO” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, эхний ээлжид зөвхөн Монгол Улсын иргэдэд Таван



толгойн ордын 30 хүртэлх хувийг Монголын хөрөнгийн биржээр хаалттай арилжаалж, хөрөнгийн эх үүсвэрийг тус компанийн хөгжлийн хөрөнгө оруулалтад чиглүүлнэ .

2.17 Сумын эмч, Сумын багш, Хөдөөгийн залуу гэр бүл, Хөдөөгийн фермер зэрэг зорилтот хөтөлбөрүүдийг нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд дэвшүүлнэ.

2.18 Хүнсний ногоо, үр тарианы үрийн нэгдсэн бодлогыг зах зээлийн эрэлт, даатгалтай уялдуулан хэрэгжүүлнэ.

2.19 Үйлчилгээний бизнесийг хөгжүүлнэ.

2.20 Эдийн засгийн болзошгүй эрсдэл, хямралаас хамгаалах худалдааны 3 давхар хамгаалалтын тогтолцоог төлөвшүүлнэ.

2.21 Үндэсний худалдааны тогтвортой өсөлтийг хангах бодлого баримтлана.

2.22 Зөвхөн худалдан авахад чиглэсэн Тендерийн хуулийг өөрчилж, захиалга үйлдвэрлэлийн бодлогоор өргөжүүлнэ.

2.23 Стратегийн хөрөнгө оруулалтын тухай хууль санаачилна.

2.24 Бизнесийн эрх зүйн шинэчлэлийг санаачилж, төрөлжүүлнэ.

2.25 Мега төслийг хэрэгжүүлэх үндэсний чадамжийг бий болгоно.

Мөнгө-зээл, төсөв-татвар

2.20 Үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг санаатайгаар унагааж, санхүүгийн хямрал зохиомлоор үүсгэсэн бол үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт тооцож, хуулийн дээд хариуцлага ногдуулна.

2.21 Монголбанкны тогтолцоог Үндсэн хуульд захируулан өөрчилж, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглоно.

2.22 Төлөх боломжгүй, өндөр хүүтэй мөнгө хүүлэх Монголбанкны бодлого, арилжааны банкны тогтолцоог засна.

2.23 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэд хараат бус Мөнгөний бодлогын хяналтын тусгай хороог байгуулж, мөнгөний бодлогын хэрэгжилт, мөнгөний нийлүүлэлт, бодлогын хүүгийн түвшин, своп хэлэлцээр, өрийн үзүүлэлт, зээлийн нөхцөлд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлнэ.

2.24 Төгрөгийн ханшны огцом уналтаас урьдчилан сэргийлэх, эрсдэлээс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг хамгаалах, хохирлыг хөнгөвчлөх хууль эрх зүй, даатгалын тогтолцоог бүрдүүлнэ.

2.25 Монгол Улсад зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр төлбөр, гүйлгээ гүйцэтгэж, зээл олгох бөгөөд гадаад валютын зээлийг үүрэг үүсэх үеийн ханшаар тооцох тухай Иргэний хуулийн 218.1 заалтыг заавал мөрдүүлэхийн төлөө тэмцэнэ.

2.26 Арилжааны банкууд дахь долларын зээлүүдийг зээлдэгчид болон банканд алдагдалгүйгээр хуульд заасан ханшаар төгрөгийн зээл болгон шилжүүлнэ.

2.27 Төгрөгийн зээлийг валютын зээлд хувиргахыг хориглож, журмыг зөрчсөн банкнийг зээлийн дүнгээр торгох, эрхийг хураах хүртэл арга хэмжээ авна.

2.28 Арилжааны банкны мөнгө хүүлэх хэт ашгийн төлөө үйл ажиллагааг таслан зогсоож, санхүүгийн үйлчилгээний байгууллагын шинж чанарыг түлхүү төлөвшүүлнэ.

2.29 Өрийн менежментийг боловсронгуй болгож, өрийн тооцооллыг олон улсын стандартад нийцүүлж, Засгийн газрын өрийг давхар өрийн зээлээр төлөхийг хориглоно.

2.30 Монголбанкнаас Засгийн газрын өрийг санхүүжүүлэх, мөнгө хэвлэж төсвийн алдагдал нөхөхийг хатуу хориглоно.

2.31 Засгийн газар Монголбанкны валютын нөөцөөс давсан өргүй байх зарчмыг тогтооно.

2.32 Эдийн засгийн хямрал, төсвийн алдагдалтай үед бүтээн байгуулалтын зээл авахыг хориглож, төсвийн орлогыг иргэддээ өндөр торгууль шийтгэл ногдуулах аргаар нөхдөг ёс суртахуунгүй бодлогыг хална.

2.33 Засгийн газрын өрийн бичгийн нийлүүлэлт, хүүгийн түвшинд тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулж, дээд хязгаар тогтооно.

2.34 Орлого, ашгаас нь үл хамаарсан татварын бодлого, тогтолцоог засч залруулна.

2.35 Эдийн засгийн хямралын үед зээлийн дарамт, ханшийн уналтад өртсөн жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд тодорхой хугацаагаар татвар, даатгалын шимтгэлийн "амралт" олгох хууль санаачилна.

2.36 УИХ-аас татварын хөнгөлөлтийн тухай хууль, Засгийн газраас татварын ершөөлийн хууль санаачлахыг хориглоно.

2.37 Төгрөгийн худалдан авах, хөрвөх чадварыг дээшлүүлэх, ханшийг тогтвортой барих хатуу бодлого барина.

2.38 Инфляц, мөнгөний ханшны уналттай уялдуулан цалин, тэтгэвэр, тэтгэмжийг заавал индексжүүлэхээр хуульчилж, төрийн нийгмийн хариуцлагыг өндөржүүлнэ.


2.39 Төрийн нэрээр авах гадаадын улс, олон улсын байгууллагын төслийн зээлийг түүний нөхцөл, үр өгөөжийг харгалзан шийдвэрлэх зарчимд шилжиж, бага хүүтэй, удаан хугацаатай, аливаа нөхцөл болзолгүй, зайлшгүй хэрэгцээт арилжааны зээлийг авахыг дэмжинэ.

2.40 Засгийн газрын тусгай сангуудын менежментийг төсөвт байгууллагаас тусгаарлаж, бие даалгах чиглэл барина.

2.41 Татвар төлөгчдийн мөнгийг үргүй зарцуулах, шамшигдуулахын эсрэг тэмцэж, ялын бодлогыг чангаруулна.

3. Их эргэлтийн бодлого: ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАТАЛГАА

Үндэсний аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар бэхжүүлж, тусгаар тогтнолоо баталгаажуулж, монгол хүн, монголын ард түмний нэр төртэй, аюулгүй, баталгаатай, эрүүл амьдрах орчныг бүрдүүлнэ.



Аюулгүй байдал

3.1 Төрийн бодлогод гадаад улс, хуулийн этгээд нөлөөлөх санаархал, оролдлогыг таслан зогсооно.

3.2 УИХ-аар хэлэлцэн дэмжигдээгүй, 2 удаа буцаагдсан хууль, тогтоолын төслийг тухайн парламентын бүрэн эрхийн хугацаанд дахин авч хэлэлцэхийг хориглоно.

3.3 Улсын нууцыг хамгаалах асуудлыг дээд түвшинд хүргэж, задруулсан, эх орноосоо урвасан этгээдэд хуулийн дээд цээрлэл үзүүлнэ.

3.4 Терроризмтой хатуу тэмцэж, түүний аливаа илрэлийг шийдвэртэй таслан зогсоож, олон улстай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3.5 Ялын дээд хэмжээ цаазаар авах ялын түдгэлзлийг эрүүгийн нөхцөл байдал, олон нийтийн санаа бодлыг харгалзан дахин авч үзнэ.

3.6 Үндсэн хуульд нийцээгүй олон улсын гэрээ, конвенцид нэгдэх, Монгол Улсад мөрдүүлэхийг хориглоно.

3.7 Үндэсний аюулгүй байдлын тогтолцоог шинэчлэн өргөжүүлж, бэхжүүлнэ,

3.8 Батлан хамгаалах бодлогыг улс төр, дипломатын аргаар бэхжүүлж, өөрийгөө хамгаалах цомхон, чадварлаг, мэргэжлийн арми, хил хамгаалах цэрэгтэй байхыг дэмжинэ.

3.9 Зөвхөн парламент зөвшөөрөн хууль баталснаар үндэсний армийг олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаа, дотоодын бүтээн байгуулалтад оролцуулахыг зөвшөөрнө.

3.10 Гадаад харилцааг улс төрийн болон эдийн засгийн дипломат бодлогыг хослуулан хөгжүүлнэ.

3.11 Хоёр хөрштэй тогтоосон найрсаг харилцаа, стратегийн түншлэлийг гүнзгийрүүлж, эдийн засгийн харилцааг либералчилна.

3.12 Дэлхийн улс орнуудтай эрх тэгш, нээлттэй, тэнцвэртэй харилцан хүндэтгэлтэй харилцааг тогтоож, дотоод хэрэгт үл оролцох зарчмыг мөрдөнө.

3.13 Эм, эмийн бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэлд хатуу хяналт тогтоож, хуурамч эмээс сэргийлсэн эдийн засаг, эрх зүйн цогц бодлого хэрэгжүүлнэ.

Байгаль орчин

3.14 Сэргээгдэх эрчим хүч, нар, салхины эрчим хүч ашиглах, хүлэмжийн хий багасгах чиглэлээр Монгол Улсын хэмжээнд баримталж байгаа хууль, олон улсын гэрээ, конвенцын заалтыг хэрэгжүүлж ажиллана.

3.15 Азийн орнуудыг монголын говийн нар, салхины эрчим хүч ашиглаж эрчим хүчээр хангах мега төсөлд Монгол Улс идэвхтэй тоглогч байх төрийн бодлогыг эрчимжүүлнэ.

3.16 Нар, ус, салхи зэрэг байгалийн нөхөн сэргээгдэх эрчим хүчийг ашиглахыг төрөөс онцгойлон дэмжинэ.



3.17 Монгол Улсад АЦС байгуулах асуудлаар нийт ард иргэдийн санал асуулга явуулахын төлөө байна.

3.18 Үйлдвэрлэлийн зориулалтаар гүний ус ашиглахад хяналт тогтооно.

3.19 Ой, усны нөөц ашигласны төлбөрийг нэмэгдүүлж, тэдгээрийг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулна.

3.20 Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хүн ам төвлөрсөн хот суурин газруудад байгуулахыг дэмжинэ.

3.21 Ой, рашаан булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, хуулийн этгээдийг төрөөс урамшуулна.

3.22 Нэн ховордсон ан амьтныг хамгаалах, ургамлыг нөхөн сэргээх тэдгээрийг дахин нутагшуулах эрх зүй, эдийн засгийн үндсийг бүрдүүлнэ.

3.23 Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх арга технологиор ашигт малтмал олборлох, уул уурхайн үйлдвэрлэл явуулахыг хуулиар хориглоно.

3.24 Иргэдийн эрүүл аюулгүй орчин, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор гаалийн болон мэргэжлийн хяналтын лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, хүнс болон байгаль орчны хяналт, шинжилгээний үр дүнг сайжруулна.

4. Их эргэлтийн бодлого: НИЙГМИЙН ШИНЭ БОДЛОГО

Боловсрол, эрүүл мэндийн чанартай, халамжийн оновчтой, даатгалын хүртээмжтэй, бүх нийтийн хөдөлмөр эрхлэлтийн нээлттэй бодлого явуулж, ард иргэдээ болзошгүй эрсдэлээс хамгаална.

Боловсрол

4.1 Үндэсний онцлогтой ерөнхий боловсролыг төрөөс онцгойлон анхаарч, сургалтын агуулга арга зүй, сурах бичгийн агуулгад улсын хэмжээгээр нэгдсэн судалгаа хийж, дүгнэлтийг УИХ-аар хэлэлцүүлж, нэгдсэн стандарт тогтооно.


4.2 Улсын нэгдсэн төвшин тогтоох шалгалтыг жил бүр, тусгайлан 10 ба 15 настнуудын дунд эх хэл, түүх, байгалийн шинжлэл, гадаад хэлний хичээлээр улс орон даяар нэгдсэн байдлаар явуулж сурлагын түвшин тогтоож байна.

4.3 Бага, дунд ангийн анги дүүргэлтийг 25-аас дээшгүй хүүхэдтэй байхаар төлөвлөнө.

4.4 Хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулиудын төлбөр, хэт ашгийн төлөөх боловсролын бизнест хяналт хэрэгжүүлнэ.

4.5 Ясли, цэцэрлэгүүдийг хувьчлан авч, үйл ажиллагааг нь өөрчилж хувьдаа завшсан хувь хүмүүс, компаниас нийтийн сайн сайхны төлөө холбогдох хуулийн хүрээнд нөхөн төлбөр авах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

4.6 Их, дээд боловсролын тогтолцоог дэлхийн жишигт хүргэх, өрсөлдөх чадвартай болгох бодлогыг хэрэгжүүлнэ.



4.7 Их, дээд сургуулиудын багшлах боловсон хүчин хүний нөөц, сонгон шалгаруулалтыг ил тод болгож, дэлхийн топ 100 сургуульд магистр, докторын зэрэг хамгаалсан залуу эрдэмтэн, судлаачдыг өргөнөөр ажиллуулна.

4.8 Их, дээд сургуулиудыг гадаадын хөрөнгө оруулалтаар дэлхийн болон Азийн шилдэг их сургуулиудын салбар сургуультай болох, сургалтын үйл ажиллагаагаа хөгжүүлэхийг дэмжинэ.

4.9 Мэргэжлийн сургалт, албан бус сургалт, зайн сургалт, түр сургалтын хэлбэрүүдийг зэрэгцүүлэн хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог нэвтрүүлнэ.

4.10 МСҮТ-ийн харъяаллыг БСШУЯ-нд шилжүүлж, мэргэжлийн сургалтыг ахлах ангийн хичээлийн хөтөлбөрт оруулснаар ерөнхий боловсролын сургуулиудын 3-р ээлжийн сургалтыг хална.

4.11 Үндэсний ажил, мэргэжлийн ангилал тогтоож, мөрдүүлнэ.

4.12 Нийгмийн хариуцлагатай хувийн хэвшлийн байгууллагын боловсролын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөхиүлэн дэмжинэ.

4.13 Улс, олон улсын олимпиадын шагналт болон гоц авъяас билигтэй сурагчид, 1,2-р курсийн шилдэг оюутнуудаас сонгон шалгаруулж, дэлхийн шилдэг их, дээд сургуулиудад тэтгэлгээр суралцуулах Үндэсний оюунтны санг төр, хувийн хэвшлийн санаачилга, хөрөнгө оруулалт, гадаадын хандив, тусламж, иргэдийн хандиваар үүсгэж, олон нийтийн хяналт, менежментэд байлгана.

Эрүүл мэнд

4.14 “Эрүүл монгол хүн” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг дэмжинэ.

4.15 Эрүүл мэндийн даатгалд ардын уламжлалт болон нөхөн сэргээх эмчилгээг хамруулахыг дэмжинэ.


4.16 Стандарт шаардлага хангасан эмнэлгүүдийг өмчийн хэлбэр үл харгалзан иргэд өөрсдөө сонгож, эрүүл мэндийн даатгалын ваучераар санхүүжүүлэх зарчмыг дэмжинэ.

4.17 Эрүүл мэндийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

Нийгмийн халамж

4.19 Нийгмийн халамжийг хөдөлмөр эрхлэх чадваргүй эмзэг хэсэг, зорилтот бүлэгт чиглүүлж, төвлөрлийг сааруулах бодлогоор орон нутагт эрх мэдэл, Нийгмийн халамжийн сангийн менежментийг бүрэн шилжүүлнэ.

4.20 Төрөлт буурч, гэр бүл салалт нэмэгдэж, хүүхдийн хөгжил саатаж буй сөрөг үзэгдлийг бууруулах зорилгоор хүүхэд төрүүлсэн эх, нэн ядуу өрхийн болон гадаадад



ажиллаж байгаа иргэдийн хүүхдүүдэд чиглэсэн улс төрийн шийдэлтэй тодорхой нийгмийн хамгааллын бодлогыг дэвшүүлнэ.

4.21 Хүүхэд төрөх, эрүүл саруул өсөж торних, амар тайван амьдралыг хангахад чиглэсэн нийгмийн хамгаалал, даатгалын зөв орчныг бүрдүүлнэ.

4.22 Залуу гэр бүлийн нийгмийн хамгааллыг сайжруулна.

4.23 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэх бодлогыг эрчимжүүлнэ.

4.24 Олон хүүхэдтэй өрх, өрх толгойлсон эх,эцэг,бүтэн өнчин хүүхдийн нийгмийн хамгааллыг сайжруулна.

4.25 Ахмад настны нийгэм хамгааллын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагууд болон хувийн хэвшлийнхнээр гүйцэтгүүлж байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

4.26 Нийгмийн халамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн хуулийн этгээдийн зардлын хоёрны нэгийг улсаас, дөрөвний нэгийг тухайн орон нутгийн төсвөөс, үлдсэн хэсгийг буюу үүсгэн байгуулагчийн гаргах хэсгийг хөрөнгө оруулалтын механизмаар шийдэх хуулийн орчныг бүрдүүлж ажиллана.

4.27 “Монгол хүний амьжиргаа хамгаалал, баталгааны тухай хууль” санаачилна.

4.28 Жилд тэрбумаас дээш орлоготой чинээлэг иргэдээс нийгмийн халамжийн төрийн бодлогыг дэмжих тусгай татвар авах хуулийн орчин бүрдүүлнэ.

Нийгмийн даатгал

4.29 Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг эхлүүлж,хувийн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.

4.30 Нийгмийн даатгалын хөрөнгийг төсвийн санхүүжилтэд ашиглахыг хориглож, менежментийг бие даасан, хараат бусаар явуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

4.31 Давхар даатгалын тогтолцоог нэвтрүүлнэ.

4.32 Гадаадад ажиллаж, амьдардаг болон хүндэтгэх шалтгаантай иргэдэд нийгмийн даатгалаа нөхөн төлөх эрх зүйн боломжийг нээнэ.

4.33 Чинээлэг хувь хүн өндөр шимтгэл төлөөд өндөр зэрэглэлийн тусгай тэтгэвэрт хамрагдаж болох хуулийн орчныг бүрдүүлнэ.

4.34 “Хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тусгай сангийн тухай хууль” санаачилна.

4.35 Жижиг, дунд үйлдвэрийн санг даатгалын тогтолцоонд шилжүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлт

4.36 Хөдөлмөрийн насны буюу эдийн засгийн идэвхтэй хүн амын хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогоор идэвхжүүлж, бүх нийтээр хөдөлмөрлөх нөхцөл, боломжоор хангана.

4.37 Хөдөлмөрийн насны иргэдийг ажилгүйдлийн даатгалд бүрэн хамруулах хууль эрх зүйн орчин бүрдүүлж, даатгалын хувь хэмжээг амьжиргааны түвшин,зах зээлийн нөхцөлтэй уялдуулан уян хатан тогтоох бодлого баримтлана.

4.38 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.



5. Их эргэлтийн бодлого: АВЛИГАГҮЙ МОНГОЛ

Авлигыг устгах, шударга ёсыг хамгаалах бодлогыг үндсэн зарчмаа болгоно.

5.1 Авлигын хэргийг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдал, учруулсан хор уршиг, хохирлын хэмжээг харгалзан ялын ялгавартай бодлого баримтлана.

5.2 Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигыг үл тэвчих орчныг бүрдүүлнэ.

5.3 Хууль, хяналтын байгууллагын эрх зүйн байдал, тогтолцооны шинэчлэлийг гүнзгийрүүлнэ.

5.4 Төрийн албаны ашиг сонирхлын зөрчилтэй хатуу тэмцэж, хариуцлагыг чангаруулна.

5.5 Үзэл суртлын агуулгатай, авлигын шинжтэй төрийн шагналын системийг халж, алдаршуулах, урамшуулах бодлого гаргана.

5.6 Ардчилсан орнуудын засгийн газрууд, олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж гадаад дотоодод байгаа олигархуудын үл хөдлөх хөрөнгө, хувьцаа болон хадгаламжийг олон нийтэд ил тод болгоно.

6. Их эргэлтийн бодлого: МЭДЛЭГТ СУУРИЛСАН НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ

Байнга хувьсан өөрчлөгдөж, эрчимтэй хөгжиж буй дэлхий ертөнцөд үнэ цэнтэй тоглогч, хүчтэй өрсөлдөгч байхын тулд цаг алдахгүй мэдлэгт тулгуурласан нээлттэй нийгмийг зорих болно.

6.1 Улс төр, эдийн засаг, нийгмийн бүх хүрээнд Монгол үндэстнийг мэдлэгт тулгуурласан нийгэмд шилжүүлэх үндэстний хөдөлгөөнийг бүх орон даяар төлөвлөгөөтэй хэрэгжүүлнэ.

6.2 Шинжлэх ухааны судалгааны тэргүүлэх чиглэлийг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, улс орны зорилттой уялдуулан тодорхойлж, хэрэгжих баталгаагаар хангана.

6.3 Төрийн бодлого төлөвлөлт, шийдвэр гаргах үйл ажиллагаа, хэрэгжүүлэлтийг шинжлэх ухаан, шинэ технологи, шилдэг менежментээр хөтөлнө.


6.4 Шинжлэх ухааны академи, их, дээд сургуулиудын судалгаа, шинжилгээний чадавхыг төвлөрүүлж, шинжлэх ухаан-сургалт-үйлдвэрлэлийн нэгдлийг үүсгэн инновацыг амилуулах, нутагшуулах стартап компаниудыг байгуулж, бизнес инкубатор төвүүдэд бойжуулна.

6.5 Инновацыг нэвтрүүлэх, өндөр технологи нутагшуулах Үндэсний техник технологийн парк, цахим программ үйлдвэрлэх Үндэсний мэдээллийн технологийн парк, блокчейн технологи хөгжүүлж, Үндэсний биг дата төв байгуулна.

6.6 Үндэсний нанотехнологи, биотехнологийн хөгжлийг дэмжинэ.

6.7 Хиймэл оюун ухааныг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлнэ.

6.8 Сансарын тухай хууль санаачилна.




6.9 Шинжлэх ухааны нээлт, бүтээл, инновацыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, цахим технологи, хиймэл оюуныг хөгжүүлэх, судалгаа шинжилгээг гүнзгийрүүлэх, оюуны чадавхыг төвлөрүүлэх, шинэ залуу боловсон хүчнийг сургах, бэлтгэх, үндэсний чадварлаг компани, шилдэг брэндийг төрүүлэх зорилгоор гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар Оюунтны хотхон байгуулах санаачилга гаргана.

7. Их эргэлтийн бодлого хэрэгжих баталгаа

Монгол Улсын иргэд сонгогчид бид өнгөрсөн 30 жилд төрийн эрх барих шууд эрхээ 7 удаа эдэлж, намууд, улстөрчдийн чанарыг 7 удаа амьдрал, ахуйгаараа хэмжжээ. Алдалгүй нэг огтлох түүхэн хариуцлага ирлээ.

Сонгогч Та бүхэн эгэл эх орончдоо нэгэн дуугаар дэмжсэнээр Их эргэлтийн бодлого, зорилтын хэрэгжих жинхэнэ баталгаа болно.



[Handwritten signatures]



ЭХ ОРОНЧДЫН НЭГДСЭН НАМД

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.04.21 № 1242
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох “Эх орончдын нэгдсэн нам”-аас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020” Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Эх орончдын нэгдсэн нам”-ын Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3. дахь хэсэг, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Эх орончдын нэгдсэн нам”-ын мөрийн хөтөлбөр / 14. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сонгуулийн Ерөнхий хороонд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0421NAG40.Docx

001052195